



**СТАНДАРТ ИНВЕСТМЕНТ**

Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер дилер

# ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ МЭДЭЭ




**2019 оны 7-р сар**

### МХБ-ийн индексүүд

Топ-20 индекс, **20,482 +6.4%** (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



МХБ-1 индекс, **9,209 +0.7%**, МХБ-2 индекс **8,122 -14.5%** (өмнөх оны мөн үетэй харьцуулсан өөрчлөлт)



### Олон улсын индексүүд

Индекс	2019.06.28	2019.07.31	Өөрчлөлт, %
DJIA (US)	26,599	26,864	+1.0%
S&P 500 (US)	2,942	2,980	+1.3%
Nikkei 225 (JP)	21,276	21,541	+1.2%
Hang Seng (HK)	28,543	27,584	-3.4%
DAX 30 (DE)	12,399	12,181	-1.8%
SMI (CH)	9,898	9,919	+0.2%

### Валютын ханш

Валют	2019.06.28	2019.07.31	Өөрчлөлт, %
USD	2,657	2,666	+0.3%
EUR	3,026	2,973	-1.8%
JPY	24.7	24.6	-0.5%
RUB	42.1	42.0	-0.2%
CNY	387.0	387.3	+0.1%
KRW	2.30	2.25	-2.2%

### Арилжааны мэдээ

Хураангуй (өмнөх сартай харьцуулсан өөрчлөлт)

Үзүүлэлт	Дүн	Өөрчлөлт, %
Арилжааны хэмжээ, тэрбум ₮	16.2	+384%
Зах зээлийн үнэлгээ, тэрбум ₮	2,515.2	-3.3%
Бүртгэлтэй компани	199	-
Арилжаалагдсан хувьцаа	72	+1.4
Арилжаалагдсан өдөр	20	

### Хамгийн их өсөлттэй

Хувьцаа	2019.06.28	2019.07.31	Өөрчлөлт, %
HBZ	281	428	52.1%
DAR	1,051	1,597	52.0%
HCH	1,480	1,954	32.0%
BUK	315	399	26.7%
MBW	293	360	22.9%

### МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

#### “ЭМ ДАБЛЮ ТИ ЭС ҮЦК” ХХК БОЛОН “ФРОНТИЕР ҮЦК” ХХК-ИЙГ МХБ-ИЙН ГИШҮҮНЧЛЭЛЭЭС ХАСЛАА

СЗХ-ны тогтоолоор үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК, “Фронтинер ҮЦК” ХХК-ийг МХБ-ийн гишүүнчлэлээс хаслаа. Эдгээр компанийн харилцагчдыг СЗХ-ноос холбогдох журмын дагуу сонгон шалгаруулах ҮЦК-д шилжүүлнэ.

#### “ЖИНСТ УВС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Жинст Увс” ХК-ийн “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-ийг өөртөө нэгтгэх шийдвэрийг СЗХ зөвшөөрсөн бөгөөд энэхүү шийдвэрийн дагуу “Ард Санхүүгийн Нэгдэл” хаалттай ХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг “Жинст Увс” ХК шилжүүлэн авч, “Жинст Увс” ХК-ийн оноосон нэрийг “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК болгон өөрчилснийг МХБ-ээс мэдээлсэн. Тус нэгтгэлтэй холбоотой компанийн үнэт цаасны арилжааг 5-р сараас эхлэн түр зогсоосон хэвээр байна. Ард санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг дараах холбоосоор орж танилцана уу. <http://ardholdings.com/mn/introduction/>

#### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2019 ОНЫ ЭЭЛЖИТ XI ХУРАЛ БОЛЛОО

7 дугаар сарын 8-ны өдөр болсон ээлжит XI хурлаар нийт 30 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд үнэт цаасны зах зээлтэй холбоотой нь “Трасс Чэйн менежемент” ХХК-д хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “Домикс сек” ХХК-д үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, “МИК актив хорь” ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон явдал байв. Дашрамд хэлэхэд энэ жил СЗХ үүсгэн байгуулагдсаны 25 жилийн ой тохиож буй аж.

#### “УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙВ

СЗХ-ноос “УИД” ХК-ийн үйл ажиллагаанд 2019 оны 3 дугаар сараас 5 дугаар сарын хооронд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. СЗХ нь “УИД” ХК-тай 2017 онд “УИД ХК-ийн үйл ажиллагааг сайжруулах, бие даасан байдлыг хангуулах гэрээ”-г байгуулсан ба тус гэрээнд “УИД” ХК-ийн барилгыг түрээслэх гэрээний үнийн дүнг тухайн үеийн зах зээлийн ханштай дүйцүүлэх...” тухай заажээ. Гэвч “УИД” ХК нь барилгаа “Номин реалтор” ХХК-д түрээслэхдээ түрээсийн гэрээг зах зээлийн үнээс хэт бага үнээр байгуулж, дээрх гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүний улмаас “УИД” ХК нь 2016 онд 3.9 тэрбум, 2017 онд 2.4 тэрбум, 2018 онд 2.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллах, нэгж хувьцаанд 2016 онд 106 төгрөг, 2017 онд 65 төгрөг, 2018 онд 71 төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр хуваарилах боломжийг тус тус алдсан байна гэж шалгалтын ажлын хэсгээс дүгнэжээ. Мөн шалгалтын ажлын хэсгээс “УИД” ХК-ийн холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бусад үйл ажиллагаанд торгууль оногдуулж, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээ авч ажиллах тухай улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлжээ.

**Хамгийн их бууралттай**

Хувьцаа	2019.06.28	2019.07.31	Өөрчлөлт, %
BHG	3,200	2,200	-31.3%
ONH	3,660	2,660	-27.3%
TEX	14,000	10,200	-27.1%
NUR	5,015	3,700	-26.2%
NKT	80	60	-25.0%

**Хамгийн идэвхтэй арилжаалагдсан**

Хувьцаа	Тоо ширхэг	Үнийн дүн, сая төг	Эзлэх, %
MIK	926,453	14,299.5	88.0%
MBW	894,961	299.5	1.8%
UBH	11,473	263.4	1.6%
BDS	308,043	240.8	1.5%
TTL	26,952	196.9	1.2%

**Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр**

Компани	Нэгж үнэ, ₮	Үнэлгээ, тэрбум ₮	Эзлэх, %
APU	559	595.0	24%
TTL	6,635	349.4	14%
MIK	14,000	289.9	12%
GOV	286	223.3	9%
INV	1,820	130.5	5%

**Зах зээлийн үнэлгээ хамгийн бага**

Компани	Нэгж үнэ, ₮	Үнэлгээ, сая ₮	Эзлэх, %
HVL	55	2.9	-
AMT	78	2.8	-
SDT	57	2.3	-
BLG	20	1.1	-
BAJ	3	0.2	-

**7-Р САРД ХАРИЛЦАГЧДЫН ҮЦТХТ ДЭХ ДАНСАНД НОГДОЛ АШИГ БАЙРШУУЛСАН КОМПАНИУД**

“Адуунчулуун” ХК, “Талын гал” ХК, “Ард даатгал” ХК-иуд 2018 оны ногдол ашгийг бүх хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсан бол “АПУ” ХК гадаадын хувьцаа эзэмшигчдийн дансанд 2018 оны ногдол ашгийг байршууллаа.

**“ГОВЬ” ХК АНУ-ЫН ЗАХ ЗЭЭЛД БҮТЭЭГДЭХҮҮНЭЭ БОРЛУУЛАХААР БОЛЖЭЭ**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга АНУ-д төрийн айлчлал хийсэн бөгөөд айлчлалаар яригдах гол сэдвүүдийн нэг нь Монголын ноос ноолууран бүтээгдэхүүнийг гаалийн татваргүйгээр АНУ руу нэвтрүүлэх талаарх яриа хэлэлцээр байв. АНУ-ын Конгрессын нэр бүхий гишүүд энэ оны 4 дүгээр сарын 11-ны өдөр оёмол, сүлжмэл бүтээгдэхүүний худалдааг нэмэгдүүлэх зорилгоор гуравдагч хөршийн худалдааны хуулийг хэлэлцүүлэхээр Конгресст өргөн барьсан юм. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монголын хувцас үйлдвэрлэлийн салбарт шинээр 40 мянган ажлын байр нэмэгдэж, 200 мянган малчны орлого нэмэгдэх аж. Дээрх үйл явдалтай зэрэгцэн, Монголын ууган үйлдвэрүүдийн нэг болох Говь ХК нь ирэх 9-р сард АНУ-ын Лос Анжелес хотод “GOBI CASHMERE USA” хэмээх цоо шинэ салбараа нээхээр болжээ. Одоогоор Говь ХК нь АНУ-ын Чикаго, Лос Анжелес, Сан Франциско зэрэг хотуудад франчайз дэлгүүртэй ба шинээр нээгдэж буй салбар компани нь АНУ-ын хэрэглэгчдэд онлайн худалдаагаар бүтээгдэхүүнээ хүргэхэд голлон анхаарч ажиллах юм байна. Энэхүү мэдээ гарсны дараа хувьцааны үнэ өсч, арилжааны идэвх дахин сэргэлээ.

**САНХҮҮГИЙН ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

МХБ-д бүртгэлтэй 199 компаниас 2019 оны 8-р сарын 6-ны байдлаар 62 компани хагас жилийн санхүүгийн тайлангаа нийтэлсэн бөгөөд үүнээс 37 компани ашигтай 25, компани алдагдалтай ажилласан байна. Компаниудын хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд ашигт ажиллагааны шинжилгээ хийж, харьцааны үзүүлэлтүүдийг үнэ ашгийн харьцаа (P/E)-аар нь эрэмбэлэн харуулав.

№	Компаниуд	Дансны үнэ	EPS, Нэгж хувьцаанд ногдох ашиг	Хаалтын ханш, 2019/07/31	P/B, Үнэ дансны үнийн харьцаа	P/E, Үнэ ашгийн харьцаа	ROA, Нийт хөрөнгийн өгөөж	ROE, Эздийн өмчийн өгөөж	Зах зээлийн үнэлгээ, сая ₮
1	Барилга корпораци	310,627.21	21603.3	405.00	0.001	0.02	6%	7%	16.47
2	Завхан баялаг	5,910.14	67.5	20.00	0.003	0.30	0%	1%	1.13
3	Ремикон	107.21	5.9	28.27	0.264	4.82	2%	5%	2,224.27
4	Мандал даатгал	2,931.08	545.4	5,175.00	1.766	9.49	8%	19%	32,307.61
5	Даваанбулаг	229.47	16.7	171.00	0.745	10.23	7%	7%	311.76
6	Могойн гол	3,748.32	737.7	8,000.00	2.134	10.84	12%	20%	6,636.98
7	Ард даатгал	457.52	53.3	709.00	1.550	13.30	6%	12%	17,725.00
8	Хөвсгөл Алтандуулга	725.98	47.2	708.00	0.975	14.99	4%	7%	11,139.81
9	Таван толгой	1,276.27	437.0	6,650.00	5.210	15.22	16%	34%	350,223.58
10	Сүү	88.52	12.2	205.00	2.316	16.84	7%	14%	70,520.00
11	Ган хэрлэн	20,343.53	313.3	5,320.00	0.262	16.98	2%	2%	531.46
12	Түмэн Шувуут	114.18	10.3	176.09	1.542	17.04	8%	9%	35,218.00
13	Лэндмн ББСБ	18.56	3.2	60.14	3.241	18.81	5%	17%	48,112.00
14	Гермес центр	106.15	6.1	120.00	1.130	19.58	6%	6%	9,425.16
15	Ард Кредит	34.20	3.8	77.00	2.251	20.14	6%	11%	21,560.00
16	Техник импорт	7,813.69	489.5	10,200.00	1.305	20.84	1%	6%	14,756.90
17	Газар сүлжмэл	30,554.67	5209.3	108,800.00	3.561	20.89	11%	17%	7,111.39
18	Мах импекс	778.79	114.9	2,506.00	3.218	21.82	4%	15%	9,524.61
19	Тахь Ко	12,882.32	356.6	10,000.00	0.776	28.04	3%	3%	11,899.83



№	Компаниуд	Дансны үнэ	EPS, Нэгж хувьцаанд ногдох ашиг	Хаалтын ханш, 2019/07/31	P/B, Үнэ дансны үнийн харьцаа	P/E, Үнэ ашгийн харьцаа	ROA, Нийт хөрөнгийн өгөөж	ROE, Эздийн өмчийн өгөөж	Зах зээлийн үнэлгээ, сая ₮
20	Инвескор	497.06	56.0	1,820.00	3.662	32.49	6%	11%	130,544.81
21	Монголын цах.холбоо	1,310.31	10.9	381.00	0.291	34.95	1%	1%	9,856.58
22	МИК холдинг	10,330.92	265.3	14,000.00	1.355	52.76	0%	3%	289,930.48
23	Говь	104.13	5.1	286.29	2.749	56.01	1%	5%	223,338.41
24	Материал импекс	17,765.48	119.3	7,000.00	0.394	58.68	0%	1%	9,577.44
25	АПУ	359.99	8.7	559.11	1.553	64.15	2%	2%	594,994.55
26	Айлтүүлс	88.15	1.3	87.55	0.993	69.53	1%	1%	3,016.28
27	Женко түр бюро	89.17	0.8	69.09	0.775	82.50	1%	1%	6,909.00
28	Монос Хүнс	42.05	0.8	69.06	1.642	83.35	2%	2%	28,235.21
29	Атар өргөө	64,306.69	691.5	58,000.00	0.902	83.87	1%	1%	10,099.89
30	Дорнод авто зам	4,084.78	26.8	2,580.00	0.632	96.16	1%	1%	193.30
31	Улсын их дэлгүүр	-28.97	4.6	500.00	-17.258	108.78	2%	-16%	18,403.93
32	Хасу мандал	3,938.28	52.3	5,690.00	1.445	108.86	1%	1%	1,774.46
33	Нэхээсгүй эдлэл	1,210.98	17.5	2,340.00	1.932	133.80	0%	1%	3,015.13
34	Монгол базальт	488.43	2.2	360.00	0.737	164.70	0%	0%	20,310.12
35	Монгол шуудан	225.30	3.1	619.00	2.747	200.20	1%	1%	61,643.96
36	Монгол шилтгээн	272.66	0.5	297.50	1.091	643.54	0%	0%	2,975.00
37	Баянгол зочид буудал	76,053.68	10.6	27,000.00	0.355	2,548.81	0%	0%	11,422.76
38	Жинст-увс	37,121.84	-1082.6	1,911.00			-2%	-3%	
39	Түшиг уул	378.20	-0.2	550.00	1.454	(2,833.64)	0%	0%	2,390.17
40	Евроазиa капитал холдинг	23.03	-1.4	1,150.00	49.937	(798.10)	-3%	-6%	60,111.53
41	Мон наб	70.62	-5.7	4,500.00	63.726	(789.22)	-1%	-8%	552.45
42	Монгол секюритиес	2.29	-0.6	400.00	174.371	(711.93)	-10%	-24%	12,000.00
43	Хоринхоёрдугаар бааз	141.07	-0.9	379.00	2.687	(433.53)	-1%	-1%	1,004.79
44	Силк нет	85.56	-2.2	708.20	8.277	(316.09)	-1%	-3%	264.88
45	Хөх ган	167.38	-0.3	80.00	0.478	(273.86)	0%	0%	8,105.40
46	Монинжбар	121.04	-1.0	115.00	0.950	(116.15)	0%	-1%	1,824.96
47	Монгол дезель	17,325.48	-4.0	410.63	0.024	(103.02)	0%	0%	56.18
48	Э-транс ложистикс	105.54	-1.8	152.00	1.440	(82.73)	-2%	-2%	7,022.40
49	Дархан зочид буудал	69.37	-2.0	150.00	2.162	(76.26)	-2%	-3%	1,341.80
50	Сэлэнгэ дулаанхаан	14.77	-14.6	793.00	53.701	(54.34)	-28%	-99%	77.21
51	УБ-бүк	227.80	-9.8	399.00	1.752	(40.89)	-3%	-4%	52,487.45
52	Фронтиэр лэнд групп	1,019.10	-14.4	195.50	0.192	(13.54)	-1%	-1%	2,688.13
53	Оллоо	136.59	-6.2	60.00	0.439	(9.61)	-4%	-5%	582.03
54	Хархорин	-1,213.82	-188.4	1,750.00	-1.442	(9.29)	-1%	16%	944.15
55	Адуун чулуун	2,575.06	-509.2	1,600.00	0.621	(3.14)	-18%	-20%	5,042.09
56	Хорго хайрхан	44.99	-35.2	60.00	1.334	(1.70)	-34%	-78%	8.11
57	Хөвсгөл усан зам	-37,043.35	-637.4	431.25	-0.012	(0.68)	-29%	2%	40.72
58	Хөнгөн бетон	-10,045.79	-490.8	200.00	-0.020	(0.41)	-2%	5%	35.87
59	Хүннү менежмент	905.06	-1929.1	427.89	0.473	(0.22)	-65%	-213%	22.17
60	Талын гал	1,389.99	-214.6	15.87	0.011	(0.07)	-7%	-15%	11.02
61	Шинэст	8,373.45	-1368.5	100.00		(0.07)			18.47
62	Хот Деволупмент	-19,959.98	-845.1	57.00	-0.003	(0.07)	-221%	4%	2.27

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ /Эх сурвалж: Монгол улсын үндэсний статистикийн хороо/**



**МӨНГӨ, ЗЭЭЛ**

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2019 оны 6 дугаар сарын эцэст 20.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 67.1 (0.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 2.9 (16.7%) их наяд төгрөгөөр өссөн байна. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 6 дугаар сарын эцэст 937.1 тэрбум болжээ.

*Хүснэгт. Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төгрөг*

Үзүүлэлт	2018.06	2019.06*
Мөнгөний нийлүүлэлт, M2	17,342.9	20,233.3
Жилийн өөрчлөлт, %	28.6	16.7
Сарын өөрчлөлт, %	1.7	- 0.3
Нийт хадгаламж	11,756.7	13,869.2
Жилийн өөрчлөлт, %	24.3	18.0
Сарын өөрчлөлт, %	1.7	- 2.4
Төгрөгийн хадгаламж	9,257.9	10,936.4
Жилийн өөрчлөлт, %	29.8	18.0
Сарын өөрчлөлт, %	1.1	- 3.1
Валютын хадгаламж	2,498.8	2,932.8
Жилийн өөрчлөлт, %	7.5	17.4
Сарын өөрчлөлт, %	4.4	0.1

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцэст 18.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 237.1 (1.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2.8 (18.3%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 6 дугаар сарын эцэст 751.1 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 69.8 (16.3%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 78.4 (9.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.1 хувийг эзэлж, өмнөх сараас 0.5 пунктээр, өмнөх оны мөн үеэс 1.3 пунктээр тус тус буурсан байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2019 оны 6 дугаар сарын эцэст 1.9 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.5 (1.3%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 596.9 (45.3%) тэрбум төгрөгөөр өсжээ. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 10.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 1.9 пунктээр өссөн байна.



**УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ**

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлээр 4.9 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.7 их наяд төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 192.2 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2019 оны 6 дугаар сард 948.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 128.6 (15.7%) тэрбум төгрөгөөр өсөж, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 902.4 тэрбум төгрөгт хүрч, 57.9 (6.0%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Татварын нийт орлого 2019 оны эхний хагас жилд 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 786.5 (21.5%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 219.7 (23.8%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 217.0 (30.7%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 98.1 (10.3%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 97.1 (28.1%) тэрбум төгрөг, онцгой албан татвар 85.7 (25.1%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 58.5 (19.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.



**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ**

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2019 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 410.0 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 156.0 сая америк доллараар өсжээ. Урсгал данс 444.1 сая америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 810.5 сая америк доллар, анхдагч орлогын данс 509.8 сая америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2019 оны эхний 5 сард 34.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 3.7 (12.0%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 646.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 8.8 (1.3%) сая америк доллараар буурчээ. Төлбөрийн тэнцэл 2019 оны эхний 5 сард 233.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 31.8 сая америк доллараар өссөн байна.



**ГАДААД ХУДАЛДАА**

Монгол Улс 2019 оны эхний хагас жилд дэлхийн 137 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 6.8 тэрбум америк доллар, үүнээс экспорт 3.9 тэрбум америк доллар, импорт 2.9 тэрбум америк долларт хүрлээ. Харин 2019 оны 6 дугаар сард экспорт 675.6 сая америк долларт, импорт 578.7 сая америк долларт хүрч, өмнөх сараас экспорт 75.8 сая америк доллараар буурч, импорт 29.9 сая америк доллараар өссөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 492.3 (7.8%) сая америк доллар, үүнээс экспорт 357.6(10.0%) сая америк доллараар, импорт 134.7 (4.9%) сая америк доллараар тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2018 оны эхний хагас жилд 822.2 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2019 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 223.0 сая америк доллараар өсөж, 1.0 тэрбум америк долларт хүрчээ. Гадаад худалдааны тэнцэл 2019 оны 6 дугаар сард 96.9 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 105.7 сая америк доллараар буурсан байна.

Экспорт 2019 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 357.6 сая америк доллараар өсөхөд чулуун нүүрсний экспорт 135.7 сая америк доллар, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт 51.4 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин импорт өмнөх оны мөн үеэс 134.7 сая америк доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний импорт 30.8 сая америк доллар, үүнээс дизелийн түлш 62.3 сая америк доллар, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 105.9 сая америк доллараар өссөн нь голлон нөлөөлжээ.



**ҮНЭ**

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.7 хувь, өмнөх оны эцсээс 4.9 хувь, өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.8 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 31.6 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.8 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 1.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 8.8 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 10.2 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 8.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 4.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 14.8 хувь (мах, махан бүтээгдэхүүн 40.9 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

## **Холбоо барих хаяг**

Стандарт инвестмент ҮЦК  
УБ хот, Сүхбаатар дүүрэг  
6-р хороо, Бага тойруу 24,  
Монреимпекс ХХК-ийн байр,  
2-р давхар, 201 тоот

Утас: 70114433  
info@standardinvestment.mn  
www.standardinvestment.mn

### **Шуудангийн хаяг:**

Төв шуудан, Шуудангийн хайрцаг 1487  
УБ - 15160

## **Тодруулга болон мэдэгдэл**

Энэхүү тойм мэдээ нь ямар нэгэн үнэт цаасыг худалдан авах, худалдах санал биш юм. Энд дурдсан үнэ ханшийн мэдээ, бусад тоон мэдээлэл, тайлбар зэрэг нь зөвхөн тухайн мэдээллийг бэлтгэх үеийн байдлыг илтгэх бөгөөд өөрчлөгдөж, хувьсаж болно /Стандарт инвестмент ҮЦК өөрчлөлтийг мэдэгдэх албагүй/. Хөрөнгө оруулагч эрсдлийг өөрөө хариуцна.

Энэхүү тойм мэдээний бүх мэдээллийг зөвхөн мэдээлэл өгөх зорилгоор бэлдсэн бөгөөд найдвартай, сайн санааны үүднээс гаргасан гэж үзсэн эх сурвалжаас авч боловсруулсан хэдий ч мэдээлэл тус бүрийг нэг бүрчлэн хянаж шалгаагүй болно. Тиймээс Стандарт инвестмент ҮЦК нь эдгээр мэдээллийн үнэн зөв, бодит бөгөөд бүрэн бүтэн байдалд баталгаа гаргахгүй бөгөөд мэдээллийг дамжуулахаас үүссэн аливаа алдааг хариуцахгүй. Түүнчлэн, энэхүү тайланг ашигласнаас учирсан аливаа хохиролд Стандарт инвестмент ҮЦК ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.